



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: ‘Боловсролын салбарын дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн цайны төлөвлөлт, зарцуулалтын үр дүн’-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Хүүхдийн хоол, үдийн цайны илчлэгийг тооцож чанартай хүнсээр хангах хэрэгцээтэй байна.

Ховд хот

2018 оны 10 сар

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар3
Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, хамрах хүрээ, зорилт, арга зүй.....4
Тэргүүлэх аудитор	Ерөнхий зүйл.....5
Л.Галбадрах	Бүлэг 1. Үдийн цайнд хамрагдах хүүхэд өдөр зарцуулах төсвийг бодиттой төлөвлөөгүй, дотоод хяналт хангалтгүй сул байна....6
Аудитын менежер	1.1 Аймгийн хэмжээнд үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхэд өдөр, төсвийг өндөр төлөвлөснөөс шалтгаалж зардлыг анх баталсан дүнгээс 47.8 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.6
А.Цэцэгсүрэн	1.2 Батлагдсан төсвийг шийдвэргүй гүйлгэн зарцуулж, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлээгүйгээс өглөгийг санхүүгийн тайлант тусгаагүй байна.7
Ахлах аудитор	1.3 Үдийн цайны худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулж байгаа ч цөөн сумдад худалдан авах ажиллагааг оновчтой хэрэгжүүлээгүй байна.....8-10
Д.Нарантуул	1.3 Үдийн цайны хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагууд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй, сургуулиуд бүтээгдэхүүний илчлэг нормыг тодорхойлох тоног төхөөрөмжгүй байна.11-12
Аудитор	Бүлэг 2. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бодитой төлөвлөөгүй, хоолны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй байна.13
Д.Балжинням	2.1 Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг анх баталсан төсвөөс 107.7 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ..... 13
2018 оны 10 дугаар сар	2.2 Дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулалтад тавих дотоод хяналт сулаас төсвийг нормативаас илүү зарцуулсан байна..... 14
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	2.3 Хүнсний бараа материалын худалдан авалт, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.....15-17
www.audit.mn	Бүлэг 3. Орон нутгийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зардлын төлөвлөлт хангалтгүй, байна..... 18
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70433061 дугаарын утас дугаарын факсаар харилцана уу?	3.1 Цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зардлын төлөвлөлтийн суурь судалгаа аймгийн хэмжээнд гаргаагүй, хүчин чадлын тооцсон дүнгээс зөрүүтэй төлөвлөж байна.....18-21
ХАЯГ: Ховд аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар	3.2 Хүүхдийн тоог өсгөж төлөвлөснөөс хоолны зардлын хэмнэлт гарч бараа үйлчилгээний бусад зардалд гүйлгэн зарцуулж, хэмнэлтийг төсөвт төвлөрүүлээгүй байна.....22-25
	3.3 Аймгийн хэмжээнд хүүхдийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг тооцон жишиг болохуйцаар хэрэгжүүлж байгаа цэцэрлэгүүд байхгүй байна.26
	3.4 Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зарцуулалтад тавих дотоод болон мэргэжлийн байгууллагын хяналт хяналтгүй байна.....27
	Дүгнэлт.....27
	Зөвлөмж.....27-28
	Зөрчлийн жагсаалт.....29
	Тэргүүлэх аудиторын тушаал30

Товчилсон үгийн тайлбар:

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХХААХҮСайд	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЦАЦС	Цаст Алтай цогцолбор сургууль
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ААН	Аж ахуйн нэгж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт-1	Үдийн цайны төлөвлөлт
Хүснэгт-2	Үдийн цайны тодотгосон төсөв
Хүснэгт-3	Төсөв, гүйцэтгэл
Хүснэгт-4	Хүүхэд өдөр, төсвийн гүйцэтгэл
Хүснэгт-5	Хүүхэд өдөр, төсвийн зарцуулалт
Хүснэгт-6	Дотуур байрны хүүхэд өдөр, төсөв
Хүснэгт-7	Сумдын 2017 оны хоолны зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл
Хүснэгт -8	Нэг хүүхдэд зарцуулсан хоолны зардал
Хүснэгт-9	Бараа материалын орлого, зарлага, үлдэгдэл
Хүснэгт-10	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын төлөвлөлт
Хүснэгт-11	Цэцэрлэгт хамрагдах хүүхдийн судалгаа
Хүснэгт-12	Төсвийн тодотгол
Хүснэгт-13	Төсвийн зарцуулалт
Хүснэгт-14	Бараа материалын үнийн судалгаа
Хүснэгт-15	Бараа материалын орлого, зарлага, үлдэгдэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Боловсролын салбарын дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн хоол, сурагчдын үдийн цайны зардлын төлөвлөлт, зарцуулалтын үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Үдийн цайны зардлыг холбогдох хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж зарцуулсан эсэх,
- Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг холбогдох хууль журмын дагуу бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх,
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг холбогдох хууль журмын дагуу үндэслэлтэй төлөвлөсөн эсэх,

Аудитын хамрах хүрээ: Аймгийн Боловсролын салбарын үдийн цай, дотуур байрны болон хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын талаарх бодлого, судалгаа, шинжилгээ, статистик мэдээ, бусад баримт материалд үндэслэн аймгийн БСУГазар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд, хүүхдийн цэцэрлэгүүд болон бусад холбогдох газруудыг 2017 оны байдлаар түүврийн аргаар хамрууллаа. Аудитын хугацаанд 11 суманд томилолтоор ажиллаж, 6 сумын санхүүгийн баримтыг аймагт татан авч холбогдох түүвэр судалгааг авч, аудитын холбогдох горим сорилыг хэрэгжүүлэв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, албан тушаалтнууд болон ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлтүүд: Аудитад Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай , Боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Хүнсний тухай, Эрүүл ахуйн тухай хуулиуд болон дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Балжинням нар гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын тайлангийн I бүлэгт үдийн цайны төлөвлөлт, зарцуулалтын үр дүн, II бүлэгт дотуур байрны хоолны төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр дүн, III бүлэгт Хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлөвлөлт, зарцуулалтын үр дүнгийн талаар тайлагнаж ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Үдийн цай хөтөлбөр нь “Тэтгэмж мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2006 оны 47 дугаар тогтоол, “Хөтөлбөр хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоол, БСШУ-ны сайд, ЭМС-ын 2006 оны 379/341 тоот тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулиудад “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам” батлагдаж, хөтөлбөрийг 2006 оноос хойш хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор ЕБС-ын 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд олгох үдийн цайны зардлыг 600, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315, цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 1650 төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Аймгийн хэмжээнд 24 ерөнхий боловсролын сургуульд 18472 сурагч суралцаж, 44 төрийн болон хувийн өмчийн хүүхдийн цэцэрлэгт 8819 хүүхэд хүмүүжиж, 17 сумдын дотуур байранд 1890 хүүхэд амьдарч, 1-5 дугаар ангийн 8943 сурагч үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор үдийн цайнд 854.6 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 769.9, дотуур байрны хүүхдийн хоолонд 1046.3 сая төгрөг батлагдаж 107.7 сая төгрөгөөр тодотгож, гүйцэтгэлээр 874.1 сая төгрөг зарцуулж 64.5 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэгийн хоолонд 1404.5 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 1377.0 сая төгрөгийн зардал гарган батлагдсан төсвийг 56.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Бүлэг 1: Үдийн цайнд хамрагдах хүүхэд өдөр зарцуулах төсвийг бодиттой төлөвлөөгүй, гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхэд өдөр, төсвийг өндөр төлөвлөснөөс шалтгаалж зардлыг анх баталсан дүнгээс 47.8 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

1.1.1. Засгийн газрын 106 дугаар тогтоолоор үдийн цайнд өдөрт 1 хүүхдэд зарцуулахаар батлагдаж аймгийн хэмжээнд 1-5 дугаар ангийн 8735 хүүхдийг үдийн цай хөтөлбөрт хамруулж үдийн цайны зардалд 854.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

1.1.2. Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цайны зардлыг тооцохдоо “хичээлийн жил, төсвийн жил тохирдоггүй учраас хамрагдах хүүхдийн тоог төлөвлөхдөө 1-4 ангийн хүүхдийн тоог дэвшүүлэн, 1 дүгээр ангид орох хүүхдийн тоог тухайн онд 6 нас хүрч байгаа бүх хүүхдийг 100 хувь сургуульд хамруулан тооцож аймгийн хэмжээний үдийн цайнд хамрагдах хүүхдийн тоог төлөвлөж, нийт зарцуулах төсвийг хамрагдах хүүхдийн тоог жилд хичээллэх хоногийн тоо болон 1 хүүхдэд зарцуулах нормативт зардлаар нь үржүүлэн төсвийг төлөвлөж байна.

Хүснэгт 1. Төлөвлөлтийн судалгаа / мян.төг/

		хүүхэд өдөр	жилд хичээллэх хоног	хүүхэд өдрийн гүйцэтгэл	Үдийн цайны норматив	ний төсөв / мян.төг/
2016-2017 оны хичээлийн жилд	I - II анги	3,662	80	292,960	600	175,776
	III - V анги	4,949	80	395,920	600	237,552
2017-2018 оны хичээлийн жилд	I - II анги	3,502	80	280,160	600	168,096
	III - V анги	5,357	85	455,345	600	273,207
НИЙТ ДҮН		8,735		1,424,385		854,631

1.1.3. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2¹ -д заасны дагуу 2017 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор үдийн цайны зардлыг 806.8 сая төгрөгөөр буюу 47.8 сая төгрөгөөр тодотгон, бараа үйлчилгээний бусад зардалд шилжүүлэн зохицуулалт хийсэн байна. Төсвийн тодотголыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Тодотгосон төсөв, хүүхэд өдөр

он	хүүхэд өдөр		хүүхэд өдрийн зөрүү	үдийн цайны зардал		
	анх баталсан	тодотгол		анх баталсан	тодотгол	зөрүү
2,015	1,387,025	1,181,323	205,702	832,215	708,794	123,421

¹ 34.2.1. дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, 34.2.3. энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах гэж заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол хийж болно

2,016	1,473,275	1,465,274	8,001	883,965	879,164	4,801
2,017	1,424,385	1,344,587	79,798	854,630	806,755	47,875

Дээрх хүснэгтээс харахад үдийн цайнд хамрагдах хүүхдийг 79798 хүүхэд өдрөөр, зарцуулах төсвийг 47875.1 мянган төгрөгөөр тодотгож байгаа нь хамрагдах хүүхэд өдөр болон төсвийг бодиттой төлөвлөөгүй байна.

Батлагдсан төсвийг шийдвэргүй гүйлгэн зарцуулж байна.

1.2.1 2017 онд аймгийн хэмжээнд үдийн цайны зардалд 806.8 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 769.1 сая төгрөгийн зардал гарган 37.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 3. Үдийн цайны зардлын төсөв, гүйцэтгэл /мян.төг/

Д/Д	сумдын нэр	хүүхэд өдөр			үдийн цайны зардал		
		төл	гүйц	зөрүү	төл	гүйц	зөрүү
1	Алтай	46,666	42,150	4,516	28,000.0	25,290.0	2,710.0
2	Булган I Сургууль	88,275	81,327	6,948	52,965.0	48,796.2	4,168.8
3	Булган II Сургууль	80,155	79,133	1,022	48,093.0	47,479.8	613.2
4	Буянт	32,892	32,468	424	19,735.2	19,531.8	203.4
5	Дарви	50,205	47,003	3,202	30,123.0	14,424.5	15,698.5
6	Дуут	13,836	13,836	-	8,301.4	8,301.4	-
7	Дөргөн	37,946	39,018	(1,072)	22,768.0	22,768.0	-
8	Зэрэг	46,288	47,892	(1,604)	27,773.0	28,735.9	(962.9)
9	Манхан	48,074	44,978	3,096	28,844.7	27,265.3	1,579.4
10	Мөст	40,912	40,477	435	24,547.0	24,286.2	260.8
11	Мөнххайрхан	29,150	26,219	2,931	17,490.0	15,731.4	1,758.6
12	Мянгад	33,400	33,482	(82)	20,040.0	20,039.6	0.4
13	Ховд	34,725	31,463	3,262	20,835.0	18,760.3	2,074.7
14	Үенч	52,542	46,877	5,665	31,525.5	31,525.5	-
15	Цэцэг	41,212	34,930	6,282	24,727.7	21,191.5	3,536.2
16	Чандмань	25,028	27,595	(2,567)	15,017.0	19,017.0	(4,000.0)
17	Эрдэнэбүрэн	21,285	17,683	3,602	12,771.0	12,629.3	141.7
18	Жаргалант сумын I сургууль	151,516	147,630	3,886	90,909.4	86,409.4	4,500.0
19	Жаргалант сумын II сургууль	65,375	63,108	2,267	39,225.0	37,925.0	1,300.0
20	Жаргалант сумын III сургууль	50,801	50,053	748	30,481.0	29,976.8	504.2
21	Жаргалант сумын YI сургууль	84,973	83,609	1,364	50,983.9	50,983.9	-
22	Жаргалант сумын YII сургууль	83,102	78,103	4,999	49,861.5	46,861.5	3,000.0
23	Жаргалант сумын ЦАЦ сургууль	100,746	100,746	-	60,448.0	60,448.0	-

24	Жаргалант сумын Прогресс сургууль	85,483	84,504	979	51,289.6	50,702.4	587.2
	ДҮН	1,344,587	1,294,284	50,303	806,755	769,081	37,674

Төсөв гүйцэтгэлээс харахад аймгийн хэмжээний сургуулиуд нийт дүнгээр 37.7 сая төсвөө хэмнэж бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.

1.2.2 Төсвийн тухай хуулийн 7.7²-д заасны дагуу 2017 онд үдийн цайны зардлаас хэмнэгдсэн төсвийг төвлөрүүлээгүй, Сангийн сайдын 216 дугаар журмын дагуу холбогдох байгууллагуудаас шийдвэр гаргуулаагүй зарцуулжээ.

- Чандмань сумын сургууль нь түлш халаалтын зардлаас 4.0 сая төгрөгийг үдийн цайны зардал гүйлгэн зарцуулсан ч 3.0 сая төгрөгийг ямар үйл ажиллагаанд зарцуулсан тодорхой бус анхан шатны баримтгүй зарцуулсанд СТА-аар акт бичигдсэн,
- Жаргалант сумын 2, 7 дугаар сургууль, Алтай, Булган, Дарви, Манхан, Мөнххайрхан, Ховд, Зэрэг, Цэцэг сумдын сургуулиуд шийдвэрэгүйгээр үдийн цайны зардлаас шатахуун, НДШ, цалингийн ашиг, томилолт, замын зардал, урсгал засварт 32.7 сая төгрөгөөр гүйлгэн зарцуулсан байна.

1.2.3. Сүүлийн 3 жилийн гүйцэтгэлээс үзэхэд хүүхэд өдрийг 2015 онд 77.7, 2016 онд 190.4, 2017 онд 50.3 мянган хүүхэд өдрөөр илүү төсөвлөснөөс батлагдсан үдийн цайны зардлыг 2015 онд 22.8, 2016 онд 57.8, 2017 онд 37.7 сая төгрөгөөр хэмнэж бараа үйлчилгээний бусад зардалд гүйлгэн зарцуулжээ.

Хүснэгт 4. Хүүхэд өдөр, төсвийн гүйцэтгэл /мян.төг/

	хүүхэд өдөр			төсөв		
	батлагдсан	гүйцэтгэл	зөрүү	батлагдсан	гүйцэтгэл	зөрүү
2015 он	1,181,323	1,103,549	77,774	708,794.2	685,976.8	22,817.4
2016 он	1,465,274	1,274,808	190,466	879,164.4	821,387.2	57,777.2
2017 он	1,344,587	1,294,284	50,303	806,754.9	769,080.7	37,674.2

Эндээс үзэхэд үдийн цайны зардлыг жил бүр тодотгон батлуулж, хэмнэлттэй зарцуулж байгаа нь төсвийг өндөр төлөвлөж

байгаатай холбоотой байна.

Ихэнх сумууд үдийн цайны худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулж, гүйцэтгэгч ААН-үүдийн үйл ажиллагаа тогтмолжсон байхад Цэцэг, Чандмань, Ховд, Жаргалант сумын худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй байна.

1.2.4 Сумдад үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу сумдын үнэлгээний хорооноос тендер зохион байгуулж, гэрээ байгуулан хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж жигдэрсэн байна.

1.2.5 Зарим сумдад зохион байгуулсан худалдан авах ажиллагаа үр дүн муутай, шалгарсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа жигдрээгүй, маргаантай асуудал үүссэн, үр өгөөж муутай ажиллаж байна. Үдийн цайнд олгох бүтээгдэхүүнийг

² Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

олон хоногоор сургууль дээрээ хадгалан журмын 1.4³ -д заалтыг зөрчин сумдын сургуулиуд аймгийн төвөөс аж ахуйн нэгж нь үдийн цайнд өгөх бүтээгдэхүүнийг 3-5 хоногоор бэлтгэн сургууль дээр хадгалж байгаа зөрчил дутагдал байна.

- *Чандмань сумын ЗДТГ-аас зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд маргаантай асуудал үүсэж шүүхийн байгууллагад хандсан байна.*
- *Цэцэг суманд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар тендерийг 2 удаа зарласан боловч сумандаа гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, удирдлагуудын үл ойлголцоос оролцоогүй тул аймгаас Хатан түнхэл ХХК-тай гэрээ байгуулан бүтээгдэхүүн олгодог,*
- *Ховд, Буянт сумдын сургуулиуд нь Хатан түнхэл ХХК-тай гэрээ байгуулан 1-5 ангийн сурагчдын үдийн цайны бүтээгдэхүүнийг компаниар суманд хүргүүлэн 3-5 хоногоор сургууль дээр хадгалан өгдөг,*

1.2.6 Жаргалант сумаас зохион байгуулсан үдийн цайны тендерт оролцох ААН-ийн борлуулалтын орлогын хэмжээг хэт өндрөөр тогтоосноос шалтгаалж өрсөлдөөнийг хязгаарлажээ.

Жаргалант сумын “ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цайны бүтээгдэхүүн үйлчилгээ” үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 багцаар 316.9 сая төгрөгийн төсөвтэйгөөр худалдан авах ажиллагааг Жаргалант сумын ЗДТГ-аас зарласан байна. Тендерийн урилгад борлуулалтын хэмжээг борлуулалтын орлого нь 100.0 сая төгрөгөөр тооцсон нь хөдөө орон нутагт хэт өндөр байгааг худалдан авах ажиллагаанд оролцсон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, бусад оролцогчид санал гаргасан байна.

Тендерийн баримт бичгийг 6 аж ахуйн нэгжүүд худалдан авч Хатан түнхэл ХХК, Ховд Скай ХХК, Баруун Алтай Энх ХХК-иуд тендерийн баримт бичгээ ирүүлж Баруун Алтай Энх ХХК нь НДШимтгэл төлдөггүй, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 15.3.2⁴ -д дахь заалтыг хангаагүй учраас тендерт оролцох боломжгүй тул хасагдсан байна.

Гэтэл Ховд Скай ХХК нь НДШ-ийн 2.0 сая төгрөгийн өртэй, эрүүл ахуйн шаардлагын дагуу хадгалж, зөөж тээвэрлэх тоног төхөөрөмжийн тээврийн хэрэгслийн хуулбарыг ирүүлээгүй бүрдүүлэх баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй боловч орон нутагт сүү цагаан, идээ үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өөр аж ахуйн нэгжгүй тул гэрээ байгуулан ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны 1,2 дугаар багцыг Хатан Түнхэл ХХК, 3 дугаар багцыг Ховд Скай ХХК бүтээгдэхүүн нийлүүлэхээр шалгарч Жаргалант сумын Засаг дарга, сургуулиудын захирал, нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй гурвалсан гэрээ байгуулан баталгаажуулан, аж ахуйн нэгж байгууллагууд сургуулиудын захиралтай байгуулсан гэрээний сунгалтыг хийж ажилласан байна.

Үдийн цай хөтөлбөрийг жишиг болохуйцаар хэрэгжүүлж байгаа сайн туршлагуудыг бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна.

1.2.7 Үдийн цай хөтөлбөр сайн хэрэгжиж байгаа сумуудын ололттой талуудыг дурдвал:

³ Үдийн цайны хүнсний бүтээгдэхүүнийг өдөр болгон татан авах ба хүнсний бүтээгдэхүүнийг сургууль дээр хадгалахыг хориглоно.

⁴ 15.3.2.тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт;

- Дарви сумын сургуулийн цайны газар сүүтэй будаа, сүүтэй каша, сүүтэй шар будаа өгдөг,
- Эрдэнэбүрэн сумын сургуульд үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлдэг “Тунгалаг ус шураг” ХХК нь өдөр бүр шинэ бүтээгдэхүүнээр үйлчилж цагаан идээг түлхүү нийлүүлдэг,
- Булган сумын I, II сургуулиудад Амин Булган ХХК, Луудайн булаг ХХК –ууд нь сургуулийн цайны газарт байрлан үйлдвэрлэл үйлчилгээ явуулах таатай орчин бүрэн бүрдсэн, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан өдөр бүр шинэ бүтээгдэхүүн олгодог, тухайн бүтээгдэхүүнийг өөрийн тусгай шошго хаягтай уутанд хийж анги бүрд өгдөг,
- Мөст сумын үдийн цайны тендерийг сумын үнэлгээний хорооноос зохион байгуулж Бооржийн гэгээ, Хос өнхрүүш ХХК, Цармын цэнхэр цалгаа ХХК-ууд шалгарч сургуулийн удирдлагууд гэрээг 2-3 сараар нь сунгалт хийж гурилан, сүү цагаан идээ, шингэн зүйлийг нийлүүлж хэвшсэн,
- Цэцэг сумын сургууль үдийн цай уухын өмнө 1-5 ангийн сурагчдын гарыг ариутгасан тааран халуун алчуураар арчуулан, компаниас үдийн цай хариуцдаг ажилтан өдөр бүр угаан ариутган бэлтгэдэг,
- Чандмань сургууль нь үдийн цайнд хамрагдаж байгаа анги бүрд санитарны сав байрлуулан цай уухын өмнө бүх хүүхдүүд гараа ариутгаж, цай уусны дараа сурагчдын амыг содтой усаар зайлуулж хэвшсэн,
- Дарви сумын сургууль 1-5 ангийн сурагчдыг анги даасан багш нь хяналт тавин гарыг нь санитолоор ариутгадаг,



Үдийн цай нийлүүлэгч ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг 3 сар тутам үнэлж, ажлын байрны эрүүл ахуйн дүгнэлтийг тогтмол хянаж ажиллах шаардлагатай байна.

1.2.8. Сумдын сургуулиуд үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжтэй “ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмын 1.3⁵ -д заасны дагуу гэрээг сунгах шийдвэрийг мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон хяналтын комисстой хамтран шийдвэрлээгүй, зарим сургуулиуд нь гэрээний хугацааг 5 сар болон жилээр хийсэн байна.

- Дуут сумын сургууль 2017 оны 1 дүгээр сарын 2-ноос 12 дугаар сарын 31 хүртэл буюу бүтэн жилээр хийсэн,
- Буянт сумын сургууль гэрээг 5 сараар байгуулсан,
- Бусад сумуудын сургууль нь гэрээнд заасны дагуу сунгалт хийсэн байна.

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлээгүйгээс өглөгийг санхүүгийн тайлант тусгаагүй байна.

1.2.9. Аймгийн хэмжээнд 2017 онд үдийн цайны зардалтай холбоотой өглөгийг тайланд тусгаагүй байна.

- Дөргөн сумын сургууль нь үдийн цай нийлүүлдэг аж ахуйн нэгжтэй тооцоо нийлээгүйгээс 448.3 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй,

⁵ Сургуулийн захирал аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээг 2-3 сарын хугацаатай байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэсний /холбогдох хяналтын байгууллагын дүгнэлт/ үндсэн дээр сунгах эсэхээ “Хяналтын комисс”-той хамтран шийдвэрлэнэ.

- Мөнххайрхан сумын сургууль 12 дугаар сард 2125.2 мянган төгрөгийг төлөөгүй санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүйд залруулах зөвлөмж өглөө.

1.2.10. Сумдын сургуулиудад үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүд нь ажлын байрны дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулаагүй, гаргасан дүгнэлт он, сар, өдөргүй байгаа нь журмын 5.1⁶ -д заасан мөрдөн ажиллаагүй байна

- ❖ Манхан сумын сургууль нь Мөнхтөмөрзаяа ХХК-тай гэрээ байгуулан үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч уг компаний ажлын байрны тодорхойлолт олгосон он, сар, өдөргүй үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэйг нотлох боломжгүй,
- ❖ Чандмань сумын “Аагтай шаргал”, “Хөшөөтийн яргай” аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах дүгнэлтийг сумын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн гаргасан,
- ❖ Үенч сумын сургууль нь үдийн цайнд олгох шингэн зүйлийг сургуулийн цайны газарт үйл ажиллагаа явуулж байгаа боловч мэргэжлийн байгууллагаас ажлын байрны дүгнэлт гаргаагүй,

1.2.11. Үдийн цай нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдийн ажлын байр нь ариун цэврийн шаардлага бүрэн хангахгүй, бараа материал хадгалах агуулахгүй, ажилчдын хувцас солих өрөөгүй хүрэлцээ муутай байна.

- Чандмань сумын Хөшөөтийн яргай хоршоо нь ажлын байр нь 1 өрөөтэй ариун цэврийн шаардлага хангахгүй, эмх цэгцгүй, тухайн өдрийн байдлаар үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнгүй, бараа материалын нөөцгүй, хувцас солих өрөөгүй,
- Дарви сумын сургууль нь Дарви Номин ХХК-тай гэрээ байгуулан гурилан бүтээгдэхүүн олгодог боловч ажлын байрны гадна орчин нөхцөл муу, хувцас солих өрөөгүй, бараа материал хадгалах агуулахгүй,
- Зэрэг сумын Сайнбайгаль заяа ХХК-ны ажлын байр нь үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг өрөөнүүд нэг дор явагдаж, бараа материал хадгалах болон ажилчдын хувцас солих өрөөнд гаднын хүн байрлуулсан,

1.2.12. Үдийн цайны цэсийг 2.1⁷ -д заасны дагуу 7-14 хоногоор батлуулан мөрдөгдөж байгаа боловч зарим сургуулиуд цэсээ батлуулаагүй, цэс зөрчин хориглосон бүтээгдэхүүн олгосон байна.

- Цэцэг сумын сургууль 2017 оны 9 дүгээр сард 21 хоногоор үдийн цайны цэс батлуулсан,
- Булган сумын I, II сургуулиудын 1-5 дугаар саруудын үдийн цайны цэс батлуулсан гэх боловч анхан шатны баримтууд байхгүй,
- Жаргалант сумын 7 дугаар сургууль нь 12 дугаар сарын 27,28-ны өдрүүдэд үдийн цайнд 704.4 мянган төгрөгийн бялуу олгосонд зөвлөмж өгөх,

Үдийн цай хөтөлбөрт сургуулиуд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч Аймгийн ЭМГ, БСУГ, МХГ-ууд чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан тайлан мэдээ, өгсөн зөвлөмж байхгүй байна.

1.2.13. Сургуулиудын эмч, сургалтын менежерүүд үдийн цайны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтыг хийж хэвшсэн байна.

⁶ Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх,

⁷ Үдийн цайны цэсийг уг тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн 7 хоног бүрээр сургуулийн эмч боловсруулж, сургуулийн захирал батална.

Тухайлбал: Алтай,Цэцэг, Мөст сумын сургуулийн сургалтын менежер нь өдөр бүрийн ирцийг анги бүрээр нэгтгэн анги даасан багшаар нь гарын үсэг зуруулан баталгаажуулан нягтлан бодогчид өгч, архив болгон хадгалсан,

1.2.14.Зарим сургуулийн эмч, менежерүүд нь гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт хийхээр журмын 6.3.2⁸, 6.3.3⁹-д зааснаар гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулж, шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг буцаасан тухай тэмдэглэлийг тухай бүрд нь хөтөлсөн байна.

Харин Жаргалант сумын сургуулиуд нь гэрээний хэрэгжилтэд хяналт тавьсан тухай асуудлыг захирлын зөвлөлд танилцуулаагүй байна.

1.2.15.“Хяналтын комисс”-ыг томилох тухай журмын 6.6¹⁰-д зааснаар хяналтын комиссыг томилон хийсэн ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган сургуулийн захирлаар батлуулан ажиллаж байгаа зарим сургуулиуд хийх ажлын төлөвлөгөөгүй байна.

- *ЦАЦСургууль нь хяналтын комиссын ажлын төлөвлөгөө захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн баталж, хяналт хийсэн тухай тэмдэглэлийг бүрэн хөтөлж хэвшсэн,*
- *Мянгад, Манхан, Мөнххайрхан, Дэргэн, Үенч, Цэцэг сумдын сургуулиуд нь хяналтын зөвлөлийн хийсэн ажлын ажлын тайлангүй,*

1.2.16.Үдийн цайны үйлчилгээнд журмын 6.4¹¹-д зааснаар “Хяналтын комисс”-ыг захирлын тушаалаар томилохдоо өдөр тутмын хяналт тавьдаг сургалтын менежер, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, нярав, нягтлан бодогч зэрэг албан тушаалтыг томилсон боловч хяналтын комиссын хийх ажлын төлөвлөгөөгүй, үдийн цайны чанарт холбогдох хяналтуудыг бүрэн тавьж ажиллаагүй байна.

1.2.17.Үдийн цай хөтөлбөрийн журмын 6.1¹²-д заасны дагуу мэргэжлийн байгууллагууд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

- *2017 онд үдийн цайны хэрэгжилтэд аймгийн Эрүүл мэндийн газар болон Мэргэжлийн хяналтын газарт 2018 оны 9 сарын 21-нд хяналт тавин хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлэх тухай албан тоот хүргүүлсэн. ЭМГ нь албан тоотгоор шалгалт хийгдээгүй гэсэн хариуг ирүүлжээ. МХГ-аас албан бичигт хариу ирүүлсэнгүй.*
- *БСУГ-т аудитад шаардлагатай баримт бичгийг ирүүлэх жагсаалтад тодорхой хүргүүлсэн ч энэ талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг аудитын явцад ирүүлсэнгүй.*

1.2.18 Журмын 6.3.7¹³-д заасныг зөрчин үдийн цай бэлтгэх болон үйлчилж буй ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамраагдаагүй, сунгалт хийгдээгүй байна.

- *Булган сумын 2 дугаар сургуулийн эмч нь 2018 оны 4 сараас эхлэн ажиллаж байгаа боловч үзлэгт хамраагдаагүй,*

⁸ Талуудын гэрээний хэрэгжилтэд байнгын хяналт тавих, гэрээг дүгнэж захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулах,

⁹ Шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг буцаах,

¹⁰ Үдийн цайны үйлчилгээнд хяналт тавьсан Хяналтын комиссын гишүүд үр дүнг сургуулийн захиралд тухай бүр нь танилцуулна,

¹¹ Үдийн цайны үйлчилгээнд сургуулийн бага ангийн эцэг эхийн зөвлөлийн даргаар ахлуулсан“Хяналтын комисс” хяналт тавина.

¹² “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн болон Боловсрол, соёлын газар, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

¹³ Үдийн цайны үйлчилгээний талаар сургуулийн захиргаа улиралд 1 удаа тухайн сурагчдын эцэг эхэд танилцуулж санал бодлыг нь тусгана

- *Жаргалант сумын 2 дугаар сургуульд 2018 оны 9 дүгээр сарын 14-нд үдийн цайны бүтээгдэхүүн тарааж байсан ажилтан болон шинээр ажилд орсон эмч эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй,*
- *Дарви сумын үдийн цайны гурилан бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуйн нэгжийн ажилчид нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй байна.*

Үдийн цайны бүтээгдэхүүний дээжийг устгахдаа нийлүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулаагүй, устгасан тухай тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй, илчлэг норм хэмжээг тодорхойлох тоног төхөөрөмжгүй байна.

1.2.19 Үдийн цайнд нийлүүлж байгаа бүтээгдэхүүнээс дээж авч хадгалсан болон устгасан тэмдэглэлийг өдөр бүр хөтлөхөөр журмын 2.7¹⁴-д заасны дагуу хэрэгжүүлж байгаа боловч дээж авсан болон устгасан сар, өдөр, цаг, минутыг бүрэн хөтлөөгүй байгаа нь сургуулиудын эмч нарын өдөр тутамд тавих хяналт хангалтгүй байна. Зарим сургуулиудын эмч нар тухайн өдөр бүтээгдэхүүнээс дээж аваагүй, дээж хадгалах хөргөгчгүй, ажилладаггүй болсон зэрэг дутагдлууд байна. Аймгийн төвийн сургуулиуд үдийн цай нийлүүлдэг аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний 2.9¹⁵-д заасан заалтыг мөрдөөгүй дээжийг устгахдаа аж ахуйн нэгжийн төлөөллийг байлцуулан устгаагүй байна.

- *Жаргалант сумын I, II, III, VI, VII, ЦАЦС, Прогресс, Ховд сумын сургуулиуд нь үдийн цайнд олгож байгаа бүтээгдэхүүнээс дээж авч хадгалан устгахдаа компаний төлөөллийг оролцуулаагүй,*
- *Сургуулиуд дээж авсан болон устгасан тэмдэглэлд цаг, минутыг бүрэн бичдээгүй, эмч гарын үсэг зураагүй,*
- *Прогресс сургууль 2018 оны 9 дүгээр сарын 10-14 ны өдрийн дээж аваагүй*
- *Эрдэнэбүрэн сумын сургууль 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн бүтээгдэхүүнээс дээж аваагүй,*

1.2.20 Сургуулийн эмчид үдийн цайнд олгогдож байгаа бүтээгдэхүүний илчлэг норм, ккал, хэмжээг тодорхойлох тоног төхөөрөмж байхгүйгээс, тухайн өдөрт ирж байгаа бүтээгдэхүүнийг нүдэн баримжаагаар тогтоож байна.

Бүлэг 2: Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бодитой төлөвлөөгүй, хоолны зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг анх баталсан төсвөөс 107.7 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

2.1.1. Аймгийн хэмжээнд 2017 онд сумуудын дотуур байранд 1890 хүүхэд амьдарч, хоолны зардалд 1046.4 сая төгрөгөөр батлагджээ.

2.1.2. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг сүүлийн 3 жилийн төсөв, гүйцэтгэлийн судалгаанаас харахад хүүхэд өдөр, хоолны төсвийг анх баталсан төсвийг 938.7 сая төгрөгөөр буюу 107.7 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

Хүснэгт 5. Хүүхэд өдөр, төсвийн зарцуулалтын судалгаа /мян.төг/

¹⁴ Үдийн цайнд тухайн өдөр олгож буй хүнсний бүтээгдэхүүнээс дээж авч зохих журмын дагуу хадгалан, бүртгэл хөтөлнө.

¹⁵ "Үдийн цайнд ирж буй бүтээгдэхүүний дээжийг хөргөгчинд 24 цагийн турш хадгалж багш, сурагчид, эцэг эхээс хамтран ямар нэгэн хүсэлт, гомдол ирээгүй тохиолдолд компаний ажилтан сургуулийн эмч нар хамтран устгал хийж тэмдэглэл хөтлөх ба зөрчил гарсан тохиолдолд бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулан"

	хүүхэд өдөр		хүүхэд өдрийн зөрүү	төсөв		төсөв гүйцэтгэлийн зөрүү
	баталсан	гүйцэтгэл		баталсан	гүйцэтгэл	
2015 он	403,490	360,974	42,516	934,078.8	808,233.5	125,845.3
2016 он	478,962	460,968	17,994	1,108,796.2	1,074,082.9	34,713.3
2017 он	452,004	360,787	91,217	938,652.6	874,114.3	64,538.3

2.1.3. Аймгийн хэмжээний сумдын дотуур байрны хүчин чадлаар төсвийг тооцоход 533.4 мян хүүхэд өдөрт 1234.9 сая төгрөгийн төсөв шаардлагатай байгаа бол 2017 онд 452.0 мян хүүхэд өдөрт 1046.4 сая төгрөгийг төсөвлөн баталснаас үзэхэд хүчин чадлын 84.7 хувиар төсөвлөсөн байна.

Хүснэгт 6 Дотуур байранд амьдрах хүүхдийн тоо, хүүхэд өдөр, төсвийн судалгаа /мян.төг/

Д/Д	сумдын нэр	хүчин чадал	байранд суух хүүхдийн тоо	хүчин чадлаар тооцсон хүүхэд өдөр	батлагдсан хүүхэд өдөр	зөрүү	хүчин чадлаар тооцсон төсөв	батлагдсан төсөв	төсвийн зөрүү
1	Алтай	150	110	35,250	26,439	8,811	81,603.8	61,206.3	20,397.5
2	Булган I Сургууль	150	148	35,250	35,147	103	81,603.8	81,365.3	238.4
3	Булган II Сургууль	200	133	47,000	31,773	15,227	108,805.0	73,554.5	35,250.5
4	Буянт	100	85	23,500	20,272	3,228	54,402.5	46,929.7	7,472.8
5	Дарви	100	85	23,500	20,349	3,151	54,402.5	47,107.9	7,294.6
6	Дуут	50	82	11,750	19,572	(7,822)	27,201.3	45,309.2	(18,107.9)
7	Дөргөн	80	112	18,800	26,796	(7,996)	43,522.0	62,032.7	(18,510.7)
8	Зэрэг	175	153	41,125	36,694	4,431	95,204.4	84,946.6	10,257.8
9	Манхан	75	112	17,625	26,824	(9,199)	40,801.9	62,097.6	(21,295.7)
10	Мөст	175	97	41,125	23,170	17,955	95,204.4	53,638.6	41,565.8
11	Мөнххайрхан	90	74	21,150	17,885	3,265	48,962.3	41,403.8	7,558.5
12	Мянгад	90	99	21,150	23,751	(2,601)	48,962.3	54,983.6	(6,021.3)
13	Ховд	160	220	37,600	52,423	(14,823)	87,044.0	121,359.2	(34,315.2)
14	Үенч	200	157	47,000	37,366	9,634	108,805.0	86,502.3	22,302.7
15	Цэцэг	100	50	23,500	11,970	11,530	54,402.5	27,710.6	26,692.0
16	Чандмань	175	98	41,125	23,541	17,584	95,204.4	54,497.4	40,707.0
17	Эрдэнэбүрэн	200	75	47,000	18,032	28,968	108,805.0	41,744.1	67,060.9
ДҮН		2,270	1,890	533,450	452,004	81,446	1,234,936.8	1,046,389.3	188,547.5

Хүснэгтээс харахад аймгийн хэмжээний 17 дотуур байранд 2270 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 1890 хүүхэд дотуур байранд амьдрахаар захиалга өгсний дагуу төсвийг төсөвлөсөн боловч Дуут, Дөргөн, Мянгад, Манхан, Ховд сумын дотуур байранд хүчин чадлаасаа илүү хүүхдийг дотуур байранд хамрагдахаар төлөвлөсөн байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулалтад тавих хяналт сулаас батлагдсан төсвийг нормативаас илүү зарцуулсан байна.

2.1.4. 2017 онд дотуур байрын хүүхдийн хоолны зардалд 938.7 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 874.1 сая төгрөг зарцуулж, 64.5 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна. Сумдын дотуур байранд 1890 хүүхэд хамруулахаар төсөвлөж, гүйцэтгэлээр 1596 хүүхэд хамрагдсан нь төсөвлөсөн хүүхдүүдийн 84.4 хувь, хүчин чадлын 70.3 хувийг ашигласан байна.

Хүснэгт-7. Сумдын 2017 оны хоолны зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мян.төг/

Д/Д	сумдын нэр	тодотгол	гүйцэтгэл	зөрүү
1	Алтай	48,006	47,557	449.7
2	Булган I Сургууль	76,365	55,120	21245.4
3	Булган II Сургууль	59,415	48,567	10847.9
4	Буянт	46,930	46,385	545
5	Дарви	47,108	44,778	2330
6	Дуут	35,309	35,411	-101.7
7	Дөргөн	57,033	57,658	-625.5
8	Зэрэг	74,947	71,973	2974.1
9	Манхан	53,806	48,465	5340.5
10	Мөст	51,367	51,367	0
11	Мөнххайрхан	39,404	41,802	-2398
12	Мянгад	59,657	54,264	5393.9
13	Ховд	108,584	94,333	14251.6
14	Үенч	60,355	60,355	0
15	Цэцэг	29,711	28,669	1041.9
16	Чандмань	53,147	53,147	0
17	Эрдэнэбүрэн	37,509	34,266	3243.5
	ДҮН	938,653	874,114	64,538

Эндээс үзэхэд Дуут, Дөргөн, Мөнххайрхан сумууд 0.1-2.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь өмнөх оны хоолны өглөгийг төлсөнтэй холбоотой байна. Харин бусад сумууд 0.4-21.2 сая төгрөгөөр төсвийг хэмнэж аймгийн хэмжээнд 56.0 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулсан байна.

Хүснэгт 8. Сум бүрээр 1 хүүхдэд зарцуулсан хоолны зардал

Д/Д	сумдын нэр	хүүхэд өдөр	2017 оны материалын зарлага	Нормоос илүү	Нормоос дутуу
1	Алтай	19,981	50,405.2	207.66	
2	Булган I Сургууль	26,688	72,662.1	407.65	
3	Булган II Сургууль	20,438	54,005.4	327.40	
4	Буянт	18,175	41,408.1		(36.7)
5	Дарви	22,098	54,789.0	164.37	
6	Дуут	10,852	22,126.5		(276.1)
7	Дөргөн	22,402	57,628.0	257.45	
8	Зэрэг	34,095	72,228.0		(196.57)
9	Манхан	21,201	52,143.5	144.48	
10	Мөст	21,496	56,737.6	324.45	
11	Мөнххайрхан	14,508	33,333.6		(17.4)
12	Мянгад	22,983	59,561.2	276.53	
13	Ховд	37,435	87,044.0	10.20	
14	Үенч	26,507	67,011.7	213.08	
15	Цэцэг	11,334	27,071.4	73.51	
16	Чандмань	15,760	38,159.7	106.30	
17	Эрдэнэбүрэн	14,834	34,114.2		(15.3)
	ДҮН	360,787	880,429.0	125.30	

2.1.5. Дотуур байрны 1 хүүхдэд нормоор өдөрт 2315 төгрөгийн хоолны зардал гаргахаар тогтоосон боловч Дуут сумын сургууль 276 төгрөгөөр хэмнэсэн бол Булган сумын 1 дүгээр сургууль 407 төгрөгөөр илүү зарцуулсан байна.

- Мөнххайрхан, Дуут, Зэрэг, Буянт, Эрдэнэбүрэн сумын сургууль нь 1 хүүхдэд олгох хоолны зардлыг хэмнэсэн бол бусад сумдын сургуулиуд нь хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүнсний бараа материалын худалдан авалт, зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.

2.1.6. Хүүхдийн хоолонд зарцуулах хүнсний материалыг худалдан авахдаа тухайн сард хэрэглэх хэмжээгээр тооцон авдаггүй их хэмжээгээр авч хяналтгүй зарцуулж байна.

- Мянгад сумын сургууль нь 2017 онд хоолны зардалд 54.9 сая төгрөгийн төсөв батлагдсаны 65.2 хувь буюу 35.8 сая төгрөгөөр зөвхөн мах худалдан авсан. 2017 оны эхэнд 1.1 тн буюу 5.2 сая төгрөгний махны үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 7.6 тн мах худалдан авч 7.7тн махны зарлага гаргасныг нормоор тооцоход 1тн мах буюу 4.6 сая төгрөгийн махыг илүү зарцуулсанд төлүүлэх төлбөрийн акт бичих,
- Булган сумын 1 дүгээр сургууль 1 хүүхдэд зарцуулах нормоос илүү мах зарцуулсан тул СТА-аар албан шаардлага өгсөн байна.

2.1.7. БСУГ-т өгсөн дотуур байрны хүүхэд өдрийн тоог аудитын явцад сургууль бүрээр дотуур байрны багшийн ирцийн бүртгэлтэй тулгахад хүүхэд өдөр 14053-өөр зөрүүтэй байна. Мөн бараа материалын тайлангийн зарлагыг дотуур байранд амьдарсан хүүхэдтэй харьцуулж хянахад 45.2 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь дотуур байрны тогооч нь технологийн картаар тооцон материалаа авдаггүй, нярав, санхүүгийн ажилтнууд өдөр бүр 1 хүүхдэд зарцуулах нормоор тооцож хоолны талоныг бичдэггүй зэргээс хамаарч байна.

2.1.8. Дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд цагаа идээ болон эко бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаа боловч зохимжгүй бүтээгдэхүүн өгдөг, хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүнд гарал үүслийн шинжилгээний бичиг авдаггүй дутагдал байна.

- Алтай сумын сургууль хүүхдийн хоолонд уламжлалт цагаан идээ, сүү, тараг, ааруулыг хямдаар өгч хэвшсэн, сургуулийн ажилчид нь жил бүр 5 литр чацарганын өтгөрүүлсэн шүүсийг бэлтгэн хандивладаг,
- Булган сумын I, II сургуулиуд өөрийн туршлагын талбайд жимс жимсгэнэ, хүнсний ногоо тарьж 12.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн дотуур байрны хүүхдийн хоолонд хэрэглэдэг, Гэтэл Дарви, Дөргөн, Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Мянгад, Чандмань, Цэцэг, Үенч, Эрдэнэбүрэн сумын сургуулиуд хүүхдийн хоолонд нөөшилсөн алаг салат, лечо, огурцы, хиам зэрэг 13.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн авч хэрэглэсэнд зөвлөмж өгч байна.
- Бүх сумдад хүнсний материалын шинжилгээний болон гарал үүслийн бичиг авдаггүй,



Зарим эд хариуцагч нь бараа материалын тайланг бүрэн гаргадаггүй, материалын үлдэгдлийг бодитой оршин байгааг нотлох боломжгүй байна.

2.1.9. Аймгийн хэмжээний сургуулиудын 2017 оны эцэст 143.3 сая төгрөгийн бараа бараа материал үлдэгдэлтэй байна. Ихэнх сургуулиуд жилийн эцэст бараа материалын тооллого хийдэггүй, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, байгууллагын дотоод хяналт хийдэггүй алдаа дутагдал байна. Сүүлийн жилүүдэд нягтлан бодогчид ЗДТГ-т харьяалагдаж, сургууль бүр

дээр суудаггүй, 2-3 байгууллага хариуцан ачаалал ихтэй ажиллаж байгаа нь нэг талаас нөлөөлж байна. *Хүснэгт 9. Бараа материалын орлого, зарлагын үлдэгд*

Д/Д	сумдын нэр	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл
1	Алтай	2845.0	49704.0	50405.2	2143.8
2	Булган I Сургууль	20643.8	61427.2	72662.1	9408.9
3	Булган II Сургууль	29289.0	58511.1	54005.4	33794.6
4	Буянт	1485.3	46384.7	41408.1	6461.9
5	Дарви	190.0	56260.4	54789.0	1661.4
6	Дуут	3157.4	26867.9	22126.5	7898.8
7	Дөргөн	912.4	57658.2	57628.0	942.6
8	Зэрэг	17681.2	71686.8	72228.0	17140.1
9	Манхан	16887.0	50187.6	52143.5	14931.2
10	Мөст	4946.1	52374.9	56737.6	583.4
11	Мөнххайрхан	1507.4	33284.8	33333.6	1458.6
12	Мянгад	8769.2	58275.4	59561.2	7483.4
13	Ховд	5891.4	86552.9	87044.0	5400.3
14	Үенч	11135.9	59013.0	67011.7	3137.2
15	Цэцэг	1713.2	29898.9	27071.4	4540.7
16	Чандмань	9690.8	53147.4	38159.7	24678.5
17	Эрдэнэбүрэн	3561.1	32255.7	34114.2	1702.6
	ДҮН	140306.2	883490.8	880429.0	143367.9

- Булган, Зэрэг, Манхан, Чандмань сумууд 9-33 сая төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн байна.
- Эрдэнэбүрэн, Мянгад сумын сургуулиудын эд хариуцагч нар сар бүр бараа материалын тайлан гаргадаггүй дутагдал байна. Алтай сумын I сургуулийн нярав бусдад жишиг болохуйцаар хариуцсан ажлаа сайн гүйцэтгэсэн байна.

2.1.10. Дотуур байрны хүүхдийн ирцийн бүртгэлийг ЕБС-ын дотуур байрны багшийн дэвтэр хөтлөх зааврын дагуу бүртгэдэггүйгээс хоолны талон болон байрны жижүүрийн өдөр тутмын тэмдэглэл, байрны багшийн ирцийн бүртгэл дэх хүүхдийн тоо зөрдөг асуудал байна.

- Булган сумын II сургуулийн байрны багш нь 2017 оны 9 дүгээр сард дотуур байрны багшийн бүртгэлийн журналд бүртээгүй байхад хоолны талноор 2112 хүүхэд өдөрт 4.9 сая төгрөгийн хоолны зардал гаргасан,
- Үенч сумын сургуулийн байрны багш 2018 оны 9 дүгээр сарын 3-наас 9 дүгээр сарын 26 хүртэлх өдрүүдийн багшийн ирцийн бүртгэлийг хөтлөөгүй, 6.1 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөх

2.1.11. Сургуулиудын дотуур байрны хоолны газрын ажиллах нийтлэг журмыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 206 дугаар тушаалын

4.3¹⁶-д зааснаар зарим сумдын гал тогооны I, II хоолны тогоо, дээж хадгалах хөргөгч, хүнсний материал хадгалах хөргөгч, хөлдөөгч дутагдалтай байна.

- *Булган сумын II сургуулийн дотуур байрны гал тогооны I, II хоолны тогоо, хөргөгч, хөлдөөгч, шарах шүүгээ дутагдалтай, Үенч сумын сургуулийн дотуур байр нь хоолны дээж хадгалах хөргөгчгүй, Цэцэг сумын дотуур байрны дээж авдаг хөргөгч эвдэрсэн байна.*

2.1.12. Дотуур байрны ахлах тогоочийн чиг үүрэгт ХХААХҮСайдын 206 дугаар тушаалын 7.6.2¹⁷, 7.6.3¹⁸, 7.7.5¹⁹ -д зааснаар хоолны жор, технологийн карт боловсруулах, амт чанар сайтай хоол үйлдвэрлэх, хоол бүтээгдэхүүнээс дээж авах, устгах зэрэг ажлуудтай холбоотой дараах алдаа, зөрчлүүд аудитаар илэрлээ. Үүнд:

- *Аймгийн 17 дотуур байрны тогооч нараас хоолны технологийн картыг бүрэн боловсруулсан тогооч байхгүй, хоолны дээжийг устгасан тухай тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй*
- *Үенч, Дарви сумын тогооч нар хоолны дээжийг бүрэн аваагүй,*
- *Чандмань, Ховд сумдын хоолны амт чанар муу, хоолны хаягдал их гаргадаг*
- *Эрдэнэбүрэн, Зэрэг сумдын сургуулийн тогооч 2018 оны 9 дүгээр сарын хоолны цэсийг батлуулаагүй*
- *Дарви сумын дотуур байрны гал тогоонд ажиллаж байгаа ажилчид нь ЭМ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт орох хугацаа дууссан байхад хамрагдаагүй*
- *Мянгад сумын дотуур байрны тогооч хоолны талоноо бичдэггүй байрны багш нь бичдэг*
- *Зэрэг, Чандмань, Ховд сумын сургуулиуд өдрийн хоолонд I, II өгдөггүй*
- *Зэрэг сумын сургууль 2018 оны 9 сард өдрийн хоолонд “бантан” өгөхөөр ахлах тогооч нь цэс боловсруулж сургуулийн захирал баталсан байна.*

2.1.13. Дотуур байрны сурагчдын хоол хүнсний аюулгүй байдал, хоолны амт чанарт хяналт тавих зорилгоор зарим сумдын сургуулийн захирлын тушаалаар орон тооны хяналтын зөвлөл байгуулан ажиллаж гарсан дутагдлыг засаж залруулах сайжруулах талаар анхааран ажилласан байна.

- *Булган сумын I сургууль дотоод хяналтын багийг захирлын тушаалаар баталж, орон тооны хяналтын зөвлөлийн ажиллах журам, хийх ажлын төлөвлөгөө, хуваарийг гарган хяналт хийсэн тэмдэглэлийг тухай бүр хөтөлж хэвшсэн бол Дарви сумын сургууль орон тооны хяналтын зөвлөлийг байгуулан ажилласан тодорхой үр дүнгүй, хяналтын зөвлөлийн хийсэн ажлын тайлангүй байна.*

¹⁶ Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг шинж чанар, хадгалалтын нөхцлийг харгалзан шаардлага хангасан хөргүүр, хөлдөөгч, агуулахад хадгална.

¹⁷ Хоолны жор, технологи боловсруулж мөрдүүлэх, технологийн карт боловсруулах, бүтээгдэхүүний амт, чанар, аюулгүй байдалд хяналт тавих.

¹⁸ Хоолны амт чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор хоолны газрын тогооч, ажиллагсдыг мэдээллээр тогтмол хангаж, сургалт зохион байгуулах

¹⁹ Тухайн өдөр үйлдвэрлэгдсэн хоол, зууш, ундаанаас дээж авч зориулалтын саванд хийж 0⁰+4⁰С хөргөгчид 48 цаг хадгалсны дараа дээжийг устгаж тэмдэглэл хөтлөнө.

2.1.14. Аудитын явцад холбогдох тайлан мэдээ, шаардлагатай баримт бичгийг ирүүлэх жагсаалтад хүргүүлсэн ч БСУГ-ын дотуур байр хариуцсан мэргэжилтэн бүтэн жилийн хугацаанд хийсэн ажлын тайлангүй аудитын явцад 1 хуудас тайлан ирүүлж байгаагаас үзэхэд БСУГ-аас тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Бүлэг 3.1 Орон нутгийн төрийн өмчит цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зардлын төлөвлөлт хангалтгүй байна.

Цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зардлын төлөвлөлтийн суурь судалгаа аймгийн хэмжээнд гаргаагүй, хүчин чадлын тооцсон дүнгээс зөрүүтэй төлөвлөж байна.

3.1.1. 2017 оны санхүүгийн жилд Ховд аймгийн төрийн өмчийн 31 цэцэрлэгт давхардсан тоогоор 4504 хүүхэд хамруулахаар тооцож 1404.6 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусган төлөвлөжээ.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг төлөвлөхдөө Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын дагуу нэг хүүхдийн хоолны зардалд өдөрт 1650 төгрөг байхаар тооцож хамрагдах хүүхдийн хүчин чадал, жилд хичээллэх хоногийн тоогоор үржүүлэн төлөвлөхөөр тогтоолд заасан байна. Зардлын төлөвлөлтийн судалгааг 2017 оны байдлаар хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10 /мян төгрөг /

Д/д	Байгууллагын нэр	хүчин чадал	Хүчин чадлаархи төлөвлөлт	Батлагдсан төсөв	Зөрүү
1	Алтай	100	31185	35469,9	-4284,9
2	Булган	350	109147,5	112170,9	-3023,4
3	Буянт	120	37422	41382,0	-3960
4	Дарви	120	37422	38412,0	-990
5	Дөргөн	175	54573,75	57890,3	-3316,55
6	Дуут	75	23388,75	29774,3	-6385,55
7	Зэрэг	150	46777,5	57691,5	-10914
8	Манхан	140	43659	51546,0	-7887
9	Мөнххайрхан	100	31185	26829,0	4356
10	Мөст	100	31185	38346,0	-7161
11	Мянгад	75	23388,75	36940,0	-13551,25
12	Ховд	100	31185	30195,0	990
13	Үенч	100	31185	59825,0	-28640
14	Цэцэг	175	54573,75	57156,0	-2582,25
15	Чаньдмань	175	54573,75	42033,8	12539,95
16	Эрдэнэбүрэн	77	24012,45	26814,2	-2801,75
17	Ж аргалант I	98	30561,3	36630,0	-6068,7
18	Ж аргалант II	170	53014,5	45292,5	7722
19	Ж аргалант III	190	59251,5	52841,3	6410,2
20	Ж аргалант IV	175	54573,75	52841,3	1732,45
21	Ж аргалант V	175	54573,75	45292,5	9281,25
22	Ж аргалант VI	130	40540,5	40441,5	99
23	Ж аргалант VII	175	54573,75	45292,5	9281,25
24	Ж аргалант VIII	175	54573,75	55729,4	-1155,65
25	Ж аргалант IX	136	42411,6	39555,5	2856,1
26	Ж аргалант X	175	54573,75	45292,5	9281,25
27	Ж аргалант XI	170	53014,5	45292,5	7722
28	Ж аргалант XII	150	46777,5	51050,0	-4272,5
29	Ж аргалант XIII	150	46777,5	45292,5	1485
30	Ж аргалант XIV	150	46777,5	35780,5	10997
31	Ж аргалант XV	100	31185	25494,8	5690,2
	ДҮН	4451	1388044,35	1404595,2	-16550,85

Орон нутгийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг тооцож төлөвлөх аргачлалын дагуу гаргасан төлөвлөлтийн судалгаанаас харахад

- Мөнххайрхан, Ховд, Чандмань, Жаргалантын II, III, IV, V, VI, VII, IX, X, XI, XIII, XIV, XV цэцэрлэгүүдэд 0.9-12.5 сая төгрөгөөр зөрүүтэй буюу нийт тооцсон хүчин чадлаас 77.9 сая төгрөгөөр дутуу,
- Алтай, Булган, Буянт, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Манхан, Мөст, Мянгад, Үенч, Цэцэг, Эрдэнэбүрэн, Жаргалант сумын I, VIII, XII зэрэг цэцэрлэгүүдэд 0.9-13.5 сая төгрөгөөр илүү, нийт тооцсон хүчин чадлаас 98.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хамрагдах хүчин чадлаас зөрүүтэй төлөвлөж байгаа нь цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо өссөн, цэцэрлэгийн хүртээмж муу байгаагаас

шалтгаалж байгаа гэх боловч өмнөх жилүүдийн гүйцэтгэл, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн статистик тоо, хүнсний материалын үлдэгдэлтэй харьцуулсан зардлын суурь судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

3.1.2 Ховд аймгийн хэмжээнд 2017 онд цэцэрлэгт хамрагдах 2-5 насны хүүхдийн статистик тоо, цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн хувийг судалгаагаар харуулбал:

Хүснэгт 11 /хувиар /

Д/д	Байгууллагын нэр	НАС				Нийт хүүхдийн тоо	2017 онд хамрагдсан	Нийт хамрагдсан хувь
		2	3	4	5			
1	Алтай	69	74	89	81	313	100	0,32
2	Булган	222	250	252	216	940	324	0,34
3	Буянт	114	93	99	115	421	130	0,31
4	Дарви	68	94	77	80	319	131	0,41
5	Дөргөн	67	97	72	77	313	172	0,55
6	Дуут	54	47	41	55	197	90	0,46
7	Зэрэг	97	78	83	68	326	161	0,49
8	Манхан	102	105	117	115	439	120	0,27
9	Мөнххайрхан	41	65	37	47	190	68	0,36
10	Мөст	69	58	92	67	286	134	0,47
11	Мянгад	86	102	113	91	392	101	0,26
12	Ховд	90	76	113	101	380	93	0,24
13	Үенч	93	76	104	104	377	228	0,60
14	Цэцэг	86	97	94	84	361	189	0,52
15	Чаньдмань	66	67	77	58	268	131	0,49
16	Эрдэнэбүрэн	48	49	47	37	181	59	0,33
17	Жаргалант	831	768	788	745	3132	2186	0,70
	ДҮН	2203	2196	2295	2141	8835	4 416	0,50

Судалгаанаас харахад Ховд аймгийн хэмжээнд нийт цэцэрлэгт хамрагдах хүүхдийн 50% нь төрийн өмчит хүүхдийн цэцэрлэгт сурч хүмүүжиж байна.

3.1.3 Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2²⁰ дахь хэсэгт заасны дагуу Ховд аймгийн ИТХ-ын тогтоолоор нийт хоолны зардалд 2017 онд 1 удаа төсвийн тодотгол хийгдсэн байна.

Хүснэгт 12 /мян.төгрөг /

²⁰ 34.2.1. дээд шатны төсөвт тодотгол хийсний умаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон, 34.2.2. урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон, 34.2.3. энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах гэж заасны дагуу
 ҮАГ- ХОА/2018/05-ГА

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Тодотголоор	Зөрүү
1	Алтай	35469,9	34469,9	1000,0
2	Булган	112170,9	110170,9	2000,0
3	Буянт	41382,0	36384	4998,0
4	Дарви	38412,0	38412	0,0
5	Дөргөн	57890,3	28023,6	29866,7
6	Дуут	29774,3	51890,3	-22116,0
7	Зэрэг	57691,5	54170,8	3520,7
8	Манхан	51546,0	42597,4	8948,6
9	Мөнххайрхан	26829,0	41345,2	-14516,2
10	Мөст	38346,0	21577	16769,0
11	Мянгад	36940,0	29426,3	7513,7
12	Ховд	30195,0	28195	2000,0
13	Үенч	59825,0	59825	0,0
14	Цэцэг	57156,0	55824	1332,0
15	Чаньдмань	42033,8	42033,8	0,0
16	Эрдэнэбүрэн	26814,2	24814,3	1999,9
17	Ж аргалант I	36630,0	25120	11510,0
18	Ж аргалант II	45292,5	50854,2	-5561,7
19	Ж аргалант III	52841,3	54365,4	-1524,1
20	Ж аргалант IV	52841,3	51341,3	1500,0
21	Ж аргалант V	45292,5	51932,8	-6640,3
22	Ж аргалант VI	40441,5	38941,7	1499,8
23	Ж аргалант VII	45292,5	47292,5	-2000,0
24	Ж аргалант VIII	55729,4	54929,4	800,0
25	Ж аргалант IX	39555,5	29555,5	10000,0
26	Ж аргалант X	45292,5	49313,5	-4021,0
27	Ж аргалант XI	45292,5	41133,8	4158,7
28	Ж аргалант XII	51050,0	48445,2	2604,8
29	Ж аргалант XIII	45292,5	47292,5	-2000,0
30	Ж аргалант XIV	35780,5	44301,4	-8520,9
31	Ж аргалант XV	25494,8	20702,7	4792,1
	НИЙТ ДҮН	1404595,2	1354681,4	49913,8

Орон нутгийн хэмжээнд төлөвлөлт шаардлага хангахгүй байгаагаас цэцэрлэгүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр хоолны зардлыг батлагдсан төсөвт багтаан цэцэрлэгүүд хооронд нэмж тодотгох шаардлага гарч байна.

тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол хийж болно

Бүлэг 3.2 Хүүхдийн тоог өсгөж төлөвлөснөөс хоолны зардлын хэмнэлт гарч бусад зардалд гүйлгэн зарцуулжээ.

Аймгийн хэмжээнд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 56.2 сая төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг төвлөрүүлээгүй байна.

3.2.1 Аймгийн хэмжээнд 2017 онд хүүхдийн хоолны зардалд 1404.6 сая төгрөг анх батлагдаж, тодотголоор 1354.7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1331.1 сая төгрөгийн зардал гаргаж 23.6 сая төгрөгөөр зардлыг хэмнэж бусад зардалд гүйлгэн зарцуулсан нь 2017 оны 6 дугаар сарын 22 өдрийн 216 дугаар тушаалын 2.2²¹, 2.2.1²² дахь заалтуудыг зөрчиж байна.

/хүснэгт -13, мян төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Тодотголоор	Гүйцэтгэл	зөрүү
1	Алтай	35469,9	34469,9	34293,6	176,3
2	Булган	112170,9	110170,9	95727,7	14443,2
3	Буянт	41382,0	36384	38380,3	-1996,3
4	Дарви	38412,0	38412	40765,9	-2353,9
5	Дөргөн	57890,3	28023,6	28059,1	-35,5
6	Дуут	29774,3	51890,3	51890,3	0
7	Зэрэг	57691,5	54170,8	49138,2	5032,6
8	Манхан	51546,0	42597,4	37838,9	4758,5
9	Мөнххайрхан	26829,0	41345,2	41345,2	0
10	Мөст	38346,0	21577	21577	0
11	Мянгад	36940,0	29426,3	29426,3	0
12	Ховд	30195,0	28195	28121,5	73,5
13	Үенч	59825,0	59825	57031,1	2793,9
14	Цэцэг	57156,0	55824	54297	1527
15	Чаньдмань	42033,8	42033,8	42033,8	0
16	Эрдэнэбүрэн	26814,2	24814,3	24744,3	70
17	Ж аргалант I	36630,0	25120	25120	0
18	Ж аргалант II	45292,5	50854,2	50072,1	782,1
19	Ж аргалант III	52841,3	54365,4	51989,6	2375,8
20	Ж аргалант IV	52841,3	51341,3	51341,3	0
21	Ж аргалант V	45292,5	51932,8	51932,2	0,6
22	Ж аргалант VI	40441,5	38941,7	39206,2	-264,5
23	Ж аргалант VII	45292,5	47292,5	47292,5	0
24	Ж аргалант VIII	55729,4	54929,4	54929,4	0
25	Ж аргалант IX	39555,5	29555,5	33555,5	-4000
26	Ж аргалант X	45292,5	49313,5	49284,7	28,8
27	Ж аргалант XI	45292,5	41133,8	41278,5	-144,7
28	Ж аргалант XII	51050,0	48445,2	48305,5	139,7
29	Ж аргалант XIII	45292,5	47292,5	47150,9	141,6
30	Ж аргалант XIV	35780,5	44301,4	44240,6	60,8
31	Ж аргалант XV	25494,8	20702,7	20720,1	-17,4
	ДҮН	1404595,2	1354681,4	1331089,3	

²¹ 2.2. Төсвийн захирагчийн дараахь зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн зарлагын хэмнэлтэнд тооцохгүй

²² 2.2.1 “ нэгжид ногдох норм, нормативаар тооцсон төсвийн гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээ багассанаас бий болсон/ цэцэрлэгийн хүүхдийн тоо/ ”

Батлагдсан төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд хоолны зардлаас 32.4 сая төгрөг хэмнэж 8.8 сая төгрөгийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6²³ заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- Дарви сумын цэцэрлэг 2.3 сая, Буянт сумын цэцэрлэг 2.0 сая, Жаргалант сумын IX цэцэрлэг 4.0 сая төгрөгөөр хэтрүүлж,
- Булган сум 14.4 сая, Манхан сум 4.7 сая, Үенч сум 2.7 сая, Цэцэг сум 1.5 сая, Жаргалантын III цэцэрлэг 2.3 сая, Зэрэг сум 8.7 сая төгрөгөөр хоолны зардлыг хэмнэж бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.

3.2.2 Аудитын явцад томилолтоор ажилласан сум болон аймгийн төвийн цэцэрлэгүүдийн ололттой талуудыг дурдвал:

- Дарви, Эрдэнэбүрэн, Булган, Зэрэг, Мөст, Алтай, Жаргалант сумын цэцэрлэгүүд тохижилт сайн, анги танхим нь хүүхдийн сурч хүмүүжих ээлтэй орчин бүрдүүлсэн, тогооч багш нар мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдсан, хүнсний агуулах цэвэрхэн, хүүхдийн хоолны амт чанар сайн байна.
- Жаргалант сумын цэцэрлэгүүд хүүхдийн хоолны цэс, хоолны талон сүүлийн 14 хоногоор баталгаажуулсан, хоолны нэр төрөл 14 хоногт дахин давтагдаагүй, талх нарийн боорцгийг өөрсдөө хийдэг, сүү цагаан идээг түлхүү хэрэглэж, тогооч өдөр бүрийн хоолны дээжийг хадгалж жижүүр багшийн хяналтаар устгаж хэвшжээ.

Хүүхдийн хоолны материалын нийлүүлэлтийн үнэ харилцан адилгүй, хүүхдэд хүрэх хоолны зардал өндөр, материалын нэр төрөл цөөн байгаагаас харахад боловсролын салбарын хүрээнд сургууль цэцэрлэгийн нярвуудыг хооронд нь сэлгэн ажиллуулж ажлын хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

3.2.3 Хүнсний бүтээгдэхүүний харьцуулалтын үнийн судалгааг 150 хүүхэдтэй 14 цэцэрлэгийн 2017 оны жилийн хэрэглээгээр тооцож үзлээ. Жишээг судалгаагаар харуулбал:

хүснэгт 14. / төгрөгөөр/

Д/д	материалын үнэ	Жилийн хэрэгцээ	Нийлүүлсэн дээд үнэ	Нийлүүлсэн доод үнэ	Үнийн зөрүү	нийт цэцэрлэг	Нийт үнэ
1	Элсэн чихэр	700	2500	1700	800	15	8 400 000
2	Гурил	2650	1300	980	320	15	12 720 000
3	НЦТос	140	3800	3500	300	15	630 000
4	Вариан	152	3500	3000	500	15	1 140 000
5	Масло	270	3800	3000	800	15	3 240 000
6	Будаа	500	2400	2000	400	15	3 000 000
7	Сүү	430	1800	1300	500	15	3 225 000
8	Тараг	160	2500	1700	800	15	1 920 000
	ДҮН						34 275 000

Тайлбар: Тараг, сүүг нийлүүлэлт ихтэй 9, 10 сарын хэрэглээ, үнийн дүнгээр тооцсон

²³ “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”

Жаргалант сумын 15 цэцэрлэгүүдийн хүнсний материалын үнийн судалгааг тооцохдоо түгээмэл хэрэглэгдэж байгаа 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хамруулж хянав. Үүнд: будаа, гурвалжин будаа, шар будаа, хөц будаа, элсэн чихэр, наран цэцгийн тос, үзэм, гурил, чавга, вариан, масло, чацаргана, аарц, сүү, тараг

Судалгаанаас харахад ижил цаг хугацаанд нэг бэлтгэн нийлүүлэгчээс ижил хүнсний бүтээгдэхүүнийг нярвууд 100–500 төгрөгийн зөрүүтэй бэлтгэн нийлүүлдэг, төрийн сангийн үнийн мэдээтэй харьцуулахад 500–1000 төгрөгөөр зөрүүтэй байна

Дээрх хүснэгтээс үзэхэд цэцэрлэгийн нярвууд үнийн хэлбэлзэл, хүнсний материалын бөөний үнэ, төрийн сангийн үнийн судалгааг мөрдөж ажилладаггүй, цэцэрлэгийн удирдлагын дотоод хяналт сул байгаагаас үнийн зөрүүгээс хоолны зардлыг 34.2 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдагдуулсан байна.

3.2.4 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хүнсний материалын оны эхний үлдэгдэл 112.6 сая эцсийн үлдэгдэл 87.9 сая төгрөг байна.

Хүснэгт 15 Бараа материалын орлого зарцуулалт, үлдэгдлийн судалгаа /мян. төг/

Нэрс	эхний үлдэгдэл	орлого	зарлага	эцсийн үлдэгдэл
Алтай	328,4	34 293,2	31 201,0	3 420,6
Булган	12 907,5	94 372,4	100 971,6	6 308,3
Буянт	4 494,3	38 380,3	40 437,6	2 437,0
Дарви	2 349,0	40 766,0	40 766,0	2 349,0
Дөргөн	2 036,4	51 890,3	53 602,7	324,1
Дуут	3 065,6	28 059,1	28 066,8	3 058,0
Зэрэг	3 719,5	48 898,2	50 220,1	2 397,6
Манхан	5 512,3	37 742,5	37 525,3	5 729,5
Мөнххайрхан	7 740,8	21 195,0	21 201,7	7 734,1
Мөст	2 543,3	41 345,2	41 638,8	2 249,7
Мянгад	3 897,5	32 742,2	31 537,1	5 102,6
Ховд	2 052,5	28 121,5	28 980,6	1 193,4
Үенч	12 974,0	60 511,0	71 050,5	2 434,6
Цэцэг	3 090,4	58 384,4	58 870,6	2 604,3
Чаньдмань	3 102,9	42 033,8	40 872,0	4 264,7
Эрдэнэбүрэн	3 719,3	18 219,2	18 366,1	3 572,3
1- цэцэрлэг	5 888,7	25 120,0	25 698,4	5 310,3
2- цэцэрлэг	754,8	50 123,6	49 958,3	920,2
3- цэцэрлэг	3 543,2	52 211,5	54 232,5	1 522,3
4- цэцэрлэг	2 469,6	51 494,4	48 569,0	5 395,0
5- цэцэрлэг	2 141,1	51 932,2	52 995,6	1 077,8
6- цэцэрлэг	1 719,0	39 254,2	39 405,9	1 567,3
7- цэцэрлэг	5 162,9	47 291,6	50 447,6	2 006,9
8- цэцэрлэг	3 396,6	54 927,8	55 302,4	3 022,0
9- цэцэрлэг	4 431,4	34 555,5	35 330,9	3 656,1
10- цэцэрлэг	1 013,2	49 284,7	50 082,3	209,6
11-цэцэрлэг	2 411,4	40 158,4	40 584,3	1 985,5
12-цэцэрлэг	348,9	48 305,5	47 631,6	1 022,7
13-цэцэрлэг	4 093,3	47 045,5	48 355,1	2 783,7
14-цэцэрлэг	662,7	44 237,1	44 205,8	694,0
15-цэцэрлэг	1 093,3	39 481,5	38 990,5	1 584,3
ДҮН	112 664	1 352 378	1 377 098	87 937

Хүнсний материалын доод үлдэгдэл 0.2 сая дээд үлдэгдэл 12.9 сая төгрөг байгаа нь төлөвлөлт харилцан адилгүй нөгөө талдаа өндөр төлөвлөлдсөн зарцуулалтын үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүйгээр их хэмжээний материал худалдан авч нөөцөлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7²⁴-д заасан заалтыг зөрчсөн байна.

- *Үенч сумын цэцэрлэгийн 12.9 сая төгрөгийн хүнсний материалын эхний үлдэгдлийг хянаж үзэхэд тайлант онд бараа материалын тайлан гаргаагүй, 2015 оноос хойш материалын тооллого хийгээгүй, нярвын агуулахын үлдэгдэл дутагдсан, анхан шатны баримтаар нотлогдохгүй 13.1 сая төгрөгийн хүнс шууд зарлаагдсан*

3.2.5. Ховд аймгийн Жаргалант сумын хүүхдийн цэцэрлэгүүдэд хүнсний ногоо, мах нийлүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж Сэргэлэн хөрсний ундарга, Хүрэн хонх ХХК-ууд шалгарч Үнэлгээний хорооны дүгнэлтээр гэрээ байгуулан ажиллажээ.

Жаргалант сумын Засаг даргын захирамжаар Жаргалант сумын цэцэрлэгүүдэд гурил, будаа нийлүүлэх тендер зарласан боловч тендерт аж ахуйн нэгж, иргэд оролцоогүй тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна. Иймд харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулахаар 3 аж ахуйн нэгжид тендерийн урилга явуулсан боловч тендерийн материал ирүүлээгүй тул амжилтгүй болж үнэлгээний хорооноос шууд гэрээ байгуулан ажиллахыг зөвлөмж болгожээ.

3.2.6. Сумуудын цэцэрлэгт нийтлэг дараах зөрчлүүд байна. Үүнд:

- *Булган, Дарви, Эрдэнэбүрэн, Чандмань сумын цэцэрлэгүүд тог тасарсан болон хүүхдийн тоо нэмэгдсэнээс өдөрт нэг хоол өгдөг,*
- *Хүүхдийн хоолны цэс, талон батлуулаагүй,*
- *Хоолны нэр төрөл цөөн, технологийн карт хөтлөөгүй,*
- *Дээж устгалын дэвтэр хөтлөөгүй, дээж авч хадгалаагүй,*
- *Тогооч нар мэргэжлийн эмчийн үзлэгт хугацаандаа хамрагдаагүй,*
- *Хүнсний материалын шинжилгээний болон гарал үүслийн бичиг авдаагүй,*
- *Дөргөн, Чандмань, Үенч, Ховд, Дуут, Мөнххайрхан, Цэцэг сумдын цэцэрлэгүүд хоол хүнсэнд хэрэглэхийг хориглосон бүтээгдэхүүн нийлүүлж байна.*

²⁴ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ

Бүлэг 3.3: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг тооцож жишиг болохуйц хэрэгжүүлж байгаа цэцэрлэг аймгийн хэмжээнд байхгүй байна.

Тогооч нарын мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, аймгийн төвийн цэцэрлэгийн тогооч нарыг туршлага судлуулж ажиллуулах шаардлагатай байна.

3.3.1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалаар ‘хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах” тухай 5 хавсралт бүхий тушаал гарч мөн оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж эхлэхээр заасан ч тушаалыг мөрдөж ажиллахгүй байна. Уг тушаалд заасны дагуу технологийн карт хөтлөөгүй, махны хоногийн норм буурсныг тооцоогүй, мах, сүүг оруулах бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан байхад мөрдөж хэрэгжүүлээгүй байна.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэм хэмжээг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дугаар тушаалд хүүхдийн хоолыг нас хүйсийн ялгавартайгаар бэлдэн, үйлчлэх боломжгүйг харгалзан 1-3 настай хүүхдэд 1060 ккал, 4-6 настай хүүхдэд 1470 ккал илчлэгтэй хоол хүнс хэрэглэхээр тооцно гэж заажээ.

- *Аймгийн хэмжээнд 1-3 насны хүүхдэд тусгайлан хоол хийж өгч байгаа цэцэрлэг байхгүй байна.*

Цэцэрлэгийн хүүхэд өдөртөө авах ёстой илчлэгийн хэрэгцээнийхээ 70-80 хувийг цэцэрлэгийн хоол хүнснээс авахаар зааж өдөрт давтамжаар дөрвөн удаа хооллож байна.

- *Аудитын явцад аймгийн төвийн цэцэрлэгүүд, Дарви, Алтай, Булган, Эрдэнэбүрэн сумдад хоолны амт чанар, хүртээмж сайн*
- *Ховд, Чандмань, Цэцэг сумдад хүүхдийн хоолны чанар сул, хоолны цэс, хоолны талон батлуулаагүй, хоолны дээж авч хадгалаагүй байна.*

3.3.2. Жаргалант сумын IV, VI цэцэрлэг нь батлагдсан цэсээр хоолны материалыг нормын дагуу олгож нягтлан бодогч нь хоолны материалын зарцуулалт, үнэ ханшинд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

3.3.3. Аймгийн төвийн цэцэрлэгүүд хоолны цэсийн дагуу хоолны талоноор нярваас хүнсний материал хүлээн авч байгаа норм норматив харилцан адилгүй байна.

- *Тухайлбал: Хүнсэнд нийлүүлэх бүтээгдэхүүн “Талх” тухайн өдөрт цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо ижил, хүлээн авсан үндсэн материал гурилыг 8-15 кг-аар олгосон байгаагаас үзэхэд хоолны цэсэнд орох материалыг нормоор бус хүүхдийн тоог 1650 төгрөгөөр тооцон*

талоныг тааруулан бичдэг дутагдал Жаргалант сумын IV, VI цэцэрлэгээс бусад цэцэрлэгүүдэд нийтлэг байна.

3.3.4. Жаргалант сумын цэцэрлэгүүд хоолны технологийн картыг боловсруулсан ч үйл ажиллагаандаа бүрэн мөрддөггүй, сумуудын цэцэрлэгүүд технологийн карт хөтлөөгүй иж бүрэн биш, хоолны нэр төрөл цөөн, хоолны давтагдалт ойрхон, бэлэн бүтээгдэхүүн их хэмжээгээр хэрэглэдэг, мэргэжлийн тогооч ажилладаггүй, тогоочийн ур чадвар муу, үндсэн шимт бодис илчлэгийн хэрэгцээг хангаж байгааг тооцдоггүй зэрэг зөрчил дутагдал байна.

Бүлэг 3.4: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд тавих дотоод болон мэргэжлийн байгууллагын хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн цэцэрлэгүүдийн өмнөх онуудад хийсэн аудитаар хүнсний материалын үнэ, хүнсэнд хориглосон бүтээгдэхүүн нийлүүлсэн, хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.4.1. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага хангагдахгүй байгаа зөрчил дутагдал гарсаар байгаад нөлөөлж байгаа хүчин зүйл нь удирдлага болон нягтлан бодогч солигдох, сумдад нэг нягтлан бодогч 2-3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хариуцдаг, тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих боломж хомс байгаатай холбоотой байна.

3.4.2. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4²⁵-д заасан аймгийн Засаг дарга нарт хүүхэд өдрийг хянаж зөрүү тооцож байх заалт хэрэгжихгүй байна. Мөн тогтоолын 5²⁶ заасан хүүхдийн хоолны чанар, эрүүл ахуйн байдалд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ, хяналт байхгүй байна

Тус аудитаар нийтдээ дээрх зөрчил дутагдалтай холбоотой нийт 155.1 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 4.7 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж 150.4 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Аймгийн хэмжээний сургуулиудын үдийн цай, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төлөвлөлт хангалтгүй, зардлын хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй, хүүхдийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг тооцдоггүй, хоолны зардалд тавих дотоод болон мэргэжлийн байгууллагын хяналт сул байна.

²⁵ Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх

²⁶ 5. Хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, шимт бодисын хэмжээ, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэвэрт тогтмол хяналт тавьж ажиллах

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Б.Дүгэржавд:

- Боловсролын салбарын хүрээнд сургууль, цэцэрлэгийн нярвуудыг хооронд нь сэлгэн ажиллуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх
- Хүүхдийн хоолны норм, шимт бодис, илчлэгийн хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамжийн байдалд жил бүр хийх хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулах

Жаргалант сумын Засаг дарга Ц.Ганданповронд:

- Үдийн цай хөтөлбөрийн тендерийн баримт бичгийн босго үнийг хэт өндрөөр тооцож, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнт байдлыг хязгаарлаж байгааг таслан зогсоож, тендерт оролцох аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлж чанар хүртээмжид ахиц гарган ажиллах
- Жаргалант сумын сургуулиудын үдийн цай, цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зарцуулалтад төсвийн захирагчийн зүгээс хэрэгжүүлэх дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Боловсрол, соёлын газрын дарга М.Пүрэвхүүд:

- Үдийн цай, дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг бодитой тоо мэдээнд үндэслэн төлөвлөх
- Дотуур байр, цэцэрлэгийн хоол хүнсний нийлүүлэлт, түгээлт, хадгалалт, зарцуулалт, хүүхдийн хоногийн хоолны норм, шимт бодис, илчлэгийн хэрэгцээнд нийцсэн хоол хүнс хэрэглэхэд аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах
- Үдийн цай болон дотуур байр, цэцэрлэгийн хоол хүнсний нийлүүлэлт, хадгалалт, зарцуулалт, ашиглалттай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах
- Сургуулийн дотуур байрны гал тогоонд дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийн судалгааг сургууль бүрээр гарган хөрөнгө оруулалтаар хангах талаар анхааран ажиллах,

Сумдын цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч нарт

- Хүүхдийн хоногийн хоолны норм, шимт бодис, илчлэгийн хэрэгцээнд нийцсэн хоол хүнсээр хангаж мөрдөгдөж буй холбогдох стандарт, журмуудыг мөрдөж ажиллах
- Хүүхдийн хоол хүнсэнд удаан хугацаанд хадгалсан, нөөшилсөн зохимжгүй бүтээгдэхүүн хэрэглэдэг байдлыг таслан зогсоох

- Хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлийн бодит үнээр худалдан авч хүүхдийн хоолны орц, норм, хэмжээг багасгахгүй байх, зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулан нийлүүлэх ажлыг зохион байгуулах
- Үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зарцуулалтад тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, хэрэгжилтийг эцэг, эхчүүдэд тайлагнаж хэвших
- Тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх талаар тодорхой үе шаттай ажлуудыг зохион байгуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэн ажиллах

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга М.Отгонхандад

- Санхүү төрийн сангаас сар бүр гаргаж байгаа бараа материалын үнийн санал шаардлага хангахгүй байгаатай холбогдуулан нэр төрлийг олшруулах, бөөний болон жижиглэнгийн үнээр ангилах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах
- Боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг бодиттой төлөвлөх, хүүхдийн тооноос хамаарч хэмнэгдсэн зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоох


Аймгийн Мэргэжлийн Хяналтын дарга П.Эрдэнэчулуунд

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиуд, хүүхдийн цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хяналт хийж ажиллах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Байрны багшийн ирцийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй, өглөг дутуу тусгасан, хориглосон бүтээгдэхүүн олгосон, 1 хүүхдэд зарцуулах нормоос илүү хоолны зарлага гаргасан,	103.1	0	0	0	0	1	103.1
2	Мянгад сумын сургууль хүүхэд өдөрт зарцуулах нормаас илүү зарцуулсан махны үнэ төлүүлэх	4.7	0	0	1	4.7	.	
3	Бараа материалын үлдэгдэл бодитоор оршин байхгүй, анхан шатны баримтгүй шууд зарлага гаргасан	13.1					1	13.1
4	Зах зээлийн үнэ ханш, төрийн сангийн үнийн мэдээнээс өндөр дүнгээр хүнсний материал нийлүүлсэн	34.2					1	34.2
	Нийт дүн	155.1	0	0	1	4.7	3	150.4

Тайлангийн төсөлтэй танилцаад ирүүлсэн албан тоот:



Тайлангийн төсөлд өгсөн тайлбаргүй тул өөрчлөлт ороогүй болно.